

## БАЯН-АГТ СУМЫН БҮРЭН ДУНД СУРГУУЛЬД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 сарын 06-ны өдрийн 1/20 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Баян-агт сумын Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа 2017 оны 11 сарын 06-ны өдрөөс ажлын 6 хоногт багтаан шалгалтыг хийв.

### ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бүрэн дунд сургуулийн 2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, зарцуулалт, дотуур байр болон үдийн цай хөтөлбөрийн хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

### ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Баян-агт сумын 6-р багт байрлах Бүрэн дунд сургууль нь суралцагчдад суурь боловсролын стандартыг бүрэн эзэмшүүлэх, суралцах таатай орчин бүрдүүлж, мэдээллийн технологийг сургалтандаа ашигласан, хөгжсөн багш бүхий тэргүүний сургууль болох алсын хараатай. 2016 оны хичээлийн жилд 423 суралцагчид суралцсан.

2016 онд орон тооны бүтэц, цалингийн сангийн тушаал гараагүй ч захирал, сургалтын менежер 2, багш 25, дотуур байрны багш, насан туршийн боловсролын багш, нийгмийн ажилтан, номын санч, эмч, нярав, слесарь, сахиул, үйлчлэгч 3, тогооч 4, дотуур байрны жижүүр 4, галч 8 нийт 55 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл Г.Пүрэвсүрэн, 2-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Б.Оюун-эрдэнэ нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040115101 тоот, нэмэлт санхүүжилтийн 040115401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох “СТС” программаар бүртгэж хөтөлсөн байна.

#### ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус сургуулийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь түүвэрт хамрагдсан тул дүгнэлт гараагүй.

#### ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бүрэн дунд сургуулийн 2016 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт, 2016 оны санхүүгийн тайлан, дотуур байрны суралцагчдын ирцийн бүртгэл, 2016 оны хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хөдөлмөрийн дотоод журам, зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал Г.Пүрэвсүрэн, сургалтын менежер Б.Мягмарсүрэн, нягтлан бодогч Б.Оюун-эрдэнэ, нярав Ц.Сайнжаргал нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2016 онд улсын төсвөөс 651861.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 651861.5 мянган төгрөгийг авч, нийгмийн даатгалын сангаас 5949.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны 4566.9 мянган төгрөг бүгд 662377.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2016 онд төсөвт зардлыг 651861.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 662377.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажиллагсадтай холбоотой зардалд 418938.2 мянган төгрөг, ндш-д 46119.7 мянган төгрөг, тогтмол зардалд 41586.1 мянган төгрөг, нормативт зардалд 58599.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3470.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 6589.5 мянган төгрөг, албан томилолтын зардалд 312.3 мянган төгрөг, БҮТЭЗ 4507.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 637.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 7725.2 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох, тэтгэмжид 18588.0 мянган төгрөг, үдийн цай 26321.5 мянган төгрөг, ЖАТэтгэмж 5949.3 мянган төгрөг, үлдэгдэл 3904.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2016 онд Боловсролын тухай хуулийн 43.1.7 дох заалтыг үндэслэн Б.Энхтайван, Б.Хатанбаатар, Д.Мөнх-эрдэнэ, Б.Нямбат, П.Отгонтуяа нарын 5 багш, номын санч

Л.Нэргүйбаатар нарт хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж нийт 18558.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

*Нэмэлт санхүүжилтийн* 040115401 тоот дансаар БСШУЯ-наас хэрэгжүүлж буй боловсролын чанарын шинэчлэл төслийн сургуулийн тэтгэлэгт шалгаран “Ном уншингаа хөгжицгөөе” төслийн 4566.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирснийг сургалтын хэрэглэгдэхүүнд өнгөт принтер, принтерийн хор, дэлгэц, DVD, зургийн планшит, будаг харандаа, өнгийн цаас, бичгийн цаас, хавтас, тавиур, усан болон тосон будаг, үслэг даавуу мөн 76 нэр төрлийн 398 ш 1668.3 мянган төгрөгийн ном худалдан авч үндсэн хөрөнгөнд орлогодсон байна.

Цалин урамшууллын талаар: 2016 онд сургуулийн захирлын 2016 оны 03 сарын 23-ны өдрийн 04 тоот тушаалаар 52 ажилтанд 30-42%-иар 9972.0 мянган төгрөг, 2016 оны 06 сарын 14-ны өдрийн 11 тоот тушаалаар 54 ажилтанд 30-35%-иар 8747.1 мянган төгрөг, 2016 оны 09 сарын 08-ны өдрийн 19 тоот тушаалаар 56 ажилтанд 15-42%-иар 10012.6 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 19-ний өдрийн 46 тоот тушаалаар 54 ажилтанд 15-45%-иар 12032.9 мянган төгрөг нийт 40764.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.

Сургуулийн захирал нь 1-р улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг Аймгийн Засаг даргын 2016 оны 04 сарын 06-ны А/142 дугаар захирамжаар 45%-иар 330.3 мянган төгрөг, 2-р улирлын урамшууллыг 2016 оны 06 сарын 30-ны А/307 дугаар захирамжаар 45%-иар 330.3 мянган төгрөг, 2016 оны 10 сарын 17-ны А/451 дүгээр захирамжаар 45%-иар 330.3 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 20-ны А/545 дугаар захирамжаар 45%-иар 330.3 мянган төгрөг нийт 1321.2 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон. Аймгийн Засаг даргын 2016 оны 05 сарын 27-ны А/257 дугаар захирамжаар ур чадварын нэмэгдэл 20%-иар 146.8 мянган төгрөг, Сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 13-ны Б/48 дугаар захирамжаар үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж 100%-иар 734.0 мянган төгрөг тус тус олгосон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1395133224	0	0	1395133224
2	Машин тоног төхөөрөмж	111006843.40	16880000	15120167.59	112766675.81
3	Тавилга, эд хогшил	68724776.58	3500000	3781648.90	68443127.68
4	Номын фонд	12271655.30	2278300		14549955.30
6	Биет бус хөрөнгө	400000			400000
	Дүн	1587536499.28	22658300	18901816.49	1591292982.79

2016 оны эхэнд 1587536.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 1500.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 320.0 мянган төгрөгийн хөлдөөгч, 350.0 мянган төгрөг, 1200.0 мянган төгрөгийн 2 ш телевизор, 4500.0 мянган төгрөгийн видео

төхөөрөмж,1500.0 мянган төгрөгийн нано технологи дижитал,3000.0 мянган төгрөгийн Lifesize icon, 280.0 мянган төгрөгийн уур сорогч,650.0 мянган төгрөгийн өнгөт принтер, 280.0 мянган төгрөгийн дэлгэц нийт 16880.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 22278.3 мянган төгрөгийн ном худалдан авч, Орон нутгийн хөгжлийн сангийн 3500.0 мянган төгрөгөөр сурагч ширээ, сандал, багш ширээ, сандал, самбар, телевизор зэргийг авч эд хогшилд орлогодон,аймгийн ИТХ-ын 2016 оны 01 сарын 15-ны 12 тоот тогтоол, сумын ИТХ-ын 2016 оны 03 сарын 28-ны 24 тоот тогтоолуудыг үндэслэн 307.9 мянган төгрөгийн жижиг нөтбүүк 17 ш, канон, sonu телевизор, даралтат хөгжим, өнгөт принтер, ятга, DVD, модны суурь машин, 285.0 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, хөлдөөгч,1-р хоолны тогоо, ус буцалгагч зэрэг нийт 15120.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 20 нэр төрлийн 66 ш нийт 3781.6 мянган төгрөгийн эд хогшлийг акталж оны эцэст 1591292.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

**6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:**

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал	7511843.80	51374215	48939996	9946062.20
2	Бичиг хэрэг	1398779	3772520	2315209	2856090
3	Аж ахуйн материал	90310238.83	22372426	34031115.24	78651549.59
4	Тусгай зориулалтын материал	777736	0	0	777736
5	Эм боох материал	505450	390600	327800	568250
6	Сэлбэг хэрэгсэл	350000		350000	
7	Түлш шатах тослох	5880000	24753950	26454950	4179000
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>106734047.63</b>	<b>102663711</b>	<b>112419070.84</b>	<b>96978687.79</b>

2016 оны эхэнд 106734.0 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 101891.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ОНХСангаас 772.6 мянган төгрөгөөр 7 нэр төрлийн 13 ш хөгжмийн хэрэгсэл авч аж ахуйн материалд орлого авч, 100590.1 мянган төгрөгийн материал зарлагадан, 11661.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 167.7 мянган төгрөгийн өөхөн тос акталсан байна.

**6.4. Өглөг, авлагын талаар:** 2015 оны эцэст хүмүүстэй хийх тооцооны өглөг 3159.4 мянган төгрөгийн өглөгтэй байсныг барагдуулсан ч, 2016 оны эцэст 333.0 мянган төгрөгийн хаоат-ын өглөгтэй, авлагагүй тайлан баланс гарсан байна.

**6.5 Шилэн дансны талаар:** Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2017 онд нийт 114 мэдээлэл оруулахаас 105 мэдээллийг хугацаанд нь 9 мэдээллийг хугацаа хоцроосон, 2 мэдээлэл огт тавиагүй байна. Дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний мэдээллүүдийг тавиагүй байна.

## ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан. ОНХСангийн хөрөнгө оруулалтаар сургуулийн дээврийг 1500.0 мянган төгрөгөөр, спорт залны шалыг 2825.0 мянган төгрөгөөр тус тус засварласан. Тус сургуулийн төгсөгчид 2016 оны ЭЭШ-ийн дүнгээр аймагтаа 3-р байрт шалгарсан. Сурагч Г.Сумъяасүрэн монголын түүх хичээлээр 800 оноо авч, улсад оноогоор 3-рт эрэмбэлэгдсэн байна.

### НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. 2016 оны Багш ажилчдын 1-4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалт цалингийн тушаал шийдвэрүүдийг 2013 онд хүчингүй болсон 2008 оны Засгийн газрын 54 дүгээр тогтоолыг үндэслэн гаргасан байна.

2. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш ажилчдад 5 жилийн тэтгэмж олгох тушаалын үндэслэлийг Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт орж хүчингүй болсон заалтыг үндэслэн тушаал гаргасан.

3. Үдийн цай, дотуур байрны хүнс, шатахуун, түлээ, бичиг хэргийн тайлангаас бусад сэлбэг хэрэгсэл, нормын хувцас зөөлөн эдлэл, урсгал засварын материалын тайлангуудыг тусад нь гаргадаггүй, зөвхөн аж ахуйн материалын тайлангаар нэг гардаг.

4. Сумын засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 02-ны Б/05 дугаар тушаалаар сургуулийн захирал Г.Пүрэвсүрэнд Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 63/104 дугаар тушаалыг үндэслэн ур чадварын нэмэгдлийг 25%-иар 2015 оны 03 сараас эхлэн ямар хугацаатай олгох нь тодорхойгүй тушаал гарснаар 2016 онд сар бүр 183.5 мянган төгрөгийг 12 сарыг дуустал нийт 2202.0 мянган төгрөгийг олгосон.

5. Баян-агт сумын Арилжааны банканд дахь төрийн сангийн түр 120100061680 тоот дансаар 2016 онд цалин урамшуулал болон бусад материалын үнэ нийт 6895.6 мянган төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан ч кассын тайлан гаргаагүй.

6. 2016 онд шуудан холбооны зардлаас захирал, менежер, нийгмийн ажилтан, нягтлан бодогч, нярав нарын гар утасны зардалд нийт 260.0 мянган төгрөг зарцуулсан нь 2016 оны УИХ-ын 47 дугаар тогтоолын 2-д /Албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй/ гэсэн заалтыг зөрчсөн.

7. Нягтлан бодогч Б.Оюун-эрдэнэ нь шинэ компьютер худалдан авч, хуучин компьютераас санхүүгийн программ шилжүүлэн суулгах ажлаар Улаанбаатар хот явахдаа СТС-ХХК, Компьютер ланд компаниудаар 2 томилолтын хуудсаар хоног давхардуулан бөглүүлж нийт 108.0 мянган төгрөг авсан.

8. 1а ангийн багш П.Отгонтуяагийн чөлөөтэй байх хугацаанд 5 а ангийн багш Н.Өлзийбуян багш математик, монгол хэлний хичээлийг орлон 40 цаг заасныг захирлын шийдвэргүй, мөн илүү цагаар бодож /олгох-олгосон нь 152114-228171=(76056)/төгрөг илүү олгосон.

9. Багш нарын амралттай байх 7 сард үр дүнг үнэлж урамшуулалт цалин 1913051 төгрөгийг олгосон.

10. Нэмэлт санхүүжилтийн дансаар ирсэн “Ном уншингаа хөгжицгөө” төслийн санхүүгийн баримт нь 896.0 мянган төгрөгийн үндсэн баримтгүй.

11. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр аймгийн сургуулиудын хэмжээнд 3-р байр эзэлсэн тул захирлын 2016 оны 08 сарын 23-ны 15 тоот тушаалаар сургалтын

менежер, физикийн багш, газарзүйн багш нарт үндсэн цалингийн 80%-иар, нийгмийн багш, математикийн багш нарт үндсэн цалингийн 70%-иар тус бүр шагнаж 2108.2 мянган төгрөгөөр шагнасан.

12. Хүнснээс бусад бараа материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, орлого зарлагын баримт болон шаардах хуудсыг оны эхнээс дугаарлаагүй, шаардах хуудсанд нягтлан бодогч гарын үсэг зурдаггүй.

13.2016 оны 10 сарын 03-д сургалтын менежер Б.Мягмарсүрэнд 2 сар үндсэн цалингийн 20%-иар арга хэмжээ авсанч цалингаас суутган тооцоогүй.

14.Шатахууныг авсан хэмжээгээр зарлагаддаг, хэтрэлт хэмнэлтийн тооцоо боддоггүй, жолоочийн тооцооны хуудас батлагдсан маягтаар хөтөлдөггүй, түлээ нүүрсийг кассаар гарсан мөнгөн дүнгээр орлогодож зарлагаддаг.

15.Цалин олгох болон цалингийн тооцооны хүснэгт, цалингийн картанд ажиллагсдаар гарын үсэг зуруулдаггүй, гарт олгох баримтыг хэвлэж гаргадаггүй.

#### ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 3 актаар 2019.1 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлээр акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 6 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтуудын хэрэгжилт хангалтгүй, мөн шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт сул байна гэж дүгнэлээ.

#### АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Бэлэн мөнгө татаж зарцуулахыг таслан зогсоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтууд, Засгийн газрын 393 дугаар тогтоол, БСШУЯ-ны сайдын 293 дугаар тушаал, Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотгоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ О.ГАНТУЯА

